



**ОУВСангийн зөвлөмж, түүнд хийсэн дүн шинжилгээ,
Монголбанкны тухай хуулийн эдийн засаг – эрх зүйн тайлбар**
С.Дэмбэрэл¹

¹ Монголбанкны Эдийн засгийн судалгаа, сургалтын хүрээлэнгийн захирал
Цахим шуудан: demberel.s@mongolbank.mn

I. ОУВСангаас 2022 оны 10 сард Артикл IV-ийн хүрээнд гаргасан “Mission Statement”, түүнд хийсэн дүн шинжилгээ

ОУВСангийн шинжээчид Монголд ирсэн айлчлалынхаа дараа макро эдийн засгийн төлөв байдал, мөнгө, төсвийн бодлогын дүн шинжилгээг хийж холбогдох дүгнэлтүүд, зөвлөмжөө гаргадаг. Үүнийг холбогдох гол институцүүд болох Сангийн яам, Монголбанк судлан өөрчлөлт хийх, бодлогын үйл ажиллагаагаа зохицуулах гэх мэтээр хариу үйлдэл хийдэг уламжлалтай. Гэхдээ эдгээр дүгнэлт, зөвлөмж нь мөнгө төсвийн бодлого баталдаг гол институц болох УИХ-ын анхааралд тэр бүр орж, гаргаж буй хууль тогтоомж, тогтоол, шийдвэрт нь тусдаггүй. Эдийн засагчид ч тэдгээрийг онцлон анхаарч олж уншиж санал бодол, дүгнэлтээ гаргадаггүй.

Гэтэл эдгээр дүгнэлт, зөвлөмж нь Монгол Улсад хэрэгтэй олон чухал санаа, шийдлийг агуулсан байдаг тул ихээхэн анхаарвал зохих баримт бичиг юм. Тиймээс хамгийн сүүлд ОУВС-ийн шинжээчдийн гаргасан “Mission statement”-ийн нийтлэлийг илүү ойлгомжтой болгох зорилгоор POWER гэсэн хэлбэрт оруулж зохих гаргалгаа, шийдлүүд буюу дүгнэлтүүдийг гаргасан (Rationales гэсэн хэсэгт). Мөн 2019 оны 7 сард хийсэн SWOT шинжилгээ болон Монголбанкны бие даасан хараат бус байдлыг оролцуулсан Төв банкны хуулийн эрх зүйн – эдийн засгийн шинжилгээг шинэчлэн хийсэн болно.

Түүнчлэн жил бүр УИХ-аас баталдаг “Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл”-ийн төсөлд “2011-2023 онд УИХ-аар хэлэлцэх явцад нэмэгдсэн заалтуудыг Хавсралт 1-ээр үзүүлсэн. Эдгээр нэмэгдсэн заалтууд нь дефакто Төв банкны бие даасан, хараат бус байдалд УИХ-ын зүгээс хөндлөнгөөс оролцож буй хэлбэр бөгөөд Төв банк нь мөнгөний бодлогоо бие даан боловсруулж хэрэгжүүлэх, Засгийн газраас хараат бус байх болон УИХ-д тайлагнадаг байгууллага биш харин бодлого баримтлалаа танилцуулдаг, шүүмжлэл хийдэг субъект болохыг үл анхаарсан агуулгатай юм. Тиймээс хамгийн сүүлд зөвлөлдөх санал асуулгын асуултууд дотор Төв банкны бие даасан, хараат бус байдлыг ҮХНӨ-нд тусгах талаар миний боловсруулсан томъёоллыг эдийн засагч Б.Отгонтөгсийн идэвхтэй оролцоо, хүчин чармайлтаар дэмжигдсэн саналыг Монголбанкны зүгээс идэвхтэй лобби хийж бодитой хэрэгжүүлэх нь нэн чухал ач холбогдолтой юм.

Хүснэгт 1. POWER дүн шинжилгээ (ОУВСангийн 2022 оны 10 сард гаргасан "Mission Statement"-д хийсэн дүн шинжилгээ)

Positives	Opportunities	Weaknesses	Errors	Rationales
- Ковидын дараах сэргэлт, ялангуяа уул уурхайн бус сектор, ХАА-д - Глобал үнэ өсөж байгаа болон экспортын саад хязгаарлалтууд суларсан - Өрхийн бодит орлого нэмэгдсэн, 2022 оны эхнээс тэтгэврийн доод хэмжээ үлэмж нэмэгдсэн, цалин хөлсний байдал сайжирсан - 2022 23 онд сэргэлт үргэлжлэхээр байна - Нүүрсний экспорт нэмэгдэнэ. - Оюу толгойн далд уурхайн эхлэл 2023 онд нэлээд түлхэц өгнө. - Дотоод эрэлт үргэлжлэн өсөж, богино хугацаанд өсөлтийг дэмжинэ.	- Хүчтэй реформ хийх боломж бага ч Монгол Улсын эдийн засгийн хүч чадал УИХ-аас ирэх саруудад батлах бодлогын багц ялангуяа 2023 оны төсвөөс гол нь хамаарах болно. - Валютын ханшийн уян хатан байдлыг эрс нэмэгдүүлэх нь хувийн хэвшлийн гадаад өр төлбөрийн менежментэд урамшуулах түлхэц болж импортыг тогтворжуулах, дам сөрөг нөлөөг багасгана. - Төсвийн болон төсөвтэй адилтгах бодлогыг чангатгах - ГВУН-ийг нэмэгдүүлэх, позицийг сайжруулахын тулд Монголбанкны интервенцийг тогтмол бус болгох, эдийн засгийн бүх	- Дотоод гадаад тэнцлүүд алдагдсан - Дэд бүтцийн хөрөнгө оруулалт нь импортыг нэмэгдүүлж байна - ЭТТ оффтек гэрээнүүд Хятадын барилгын компаниудын санхүүжилтэд чиглэв - Капиталын гадагшлах урсгал, депозитын долларжилт, олон улсын санхүүгийн нөхцөлүүд хүндэрснээр валютын ханшид дарамт үзүүлж 22 10 сард 17.5% жилийн дүнгээрээ суларч ГВУН 2.8 тэрбум болтол буурав. - Инфляц зорилтот түвшнээс дээгүүр өссөөр байна. - Төсвийн шинжтэй ба төсвийн бодлого хэт сул хэвээр байна. - Ковидын эсрэг хуулийг 2022 оны эцэс хүртэл сунгаснаар Монголбанкны бие даасан байдлыг	- Бодлогын зохицуулалтаа эдийн засгийн гадаад дотоод орчин, тэнцвэр алдагдах тохируулах хугацаа алдсан. - Монголбанкны үйл ажиллагааны бие даасан, хараат бус байдлыг алдагдуулж төсвийн шинжтэй санхүүжилт хийхэд хүргэсэн. - Хил дээрх саад бэрхшээлүүдийг арилгах, барааны урсгалыг зохицуулах үйл ажиллагаа нэгдсэн удирдлага, уялдаа холбоо байхгүйгээс болж цаг алдсан, эдийн засгийн сэргэлтэд нөлөөлсөн. - Оффтек бартер гэрээнүүд валютын	- Эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэр алдагдах эрсдэлийг урьдчилан харах, холбогдох бодлогын арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэхэд ЗГ санаачлагч, манлайлагч байж чадахгүй байна. - Монголбанкны бие даасан, хараат бус байдлыг бэхжүүлэх хууль эрх зүйн өөрчлөлтийг 2023 онд багтаан хийх, төсвийн давамгайлал, төсвийн алдагдлыг эрс бууруулах, ТӨҮГ-ууд, ялангуяа Эрдэнэт ГОК-ын ил тод байдлыг хангах, экспорт, импортын гэрээнүүдийг ил болгох, ТӨҮГ-уудын валютын орлого, зарлагыг Монголбанк хянадаг болгох - Валютын интервенц хийж буй арга хэлбэрээ өөрчлөх, “leaning against the wind” зарчмыг тууштай хэрэгжүүлэх, УИХ-аас “ханшийг тогтворжуулах” шууд болон шууд бус дарамт үзүүлдгийг зогсоох - Төсвийн тэлсэн бодлого, нийт алдагдал түүний дотор уул уурхайн бус үндсэн алдагдлыг багасгах бодлого хэрэгжүүлэх, ЗГ-ын гадаад өрийн удирдлагыг зөвхөн Сангийн яам хэрэгжүүлж буйг өөрчилж multisectoral, stakeholders based зарчмаар боловсронгуй болгож хагас жил тутам ҮАБЗ-ийн түвшинд хэлэлцдэг болох - 2024-2025 оны төсвийн төсөөлөл, төлөвлөлтийг өөрчилж алдагдлаа ДНБ-ий 1 хувиас хэтрүүлэхгүй байх, “сонгуулийн

- Бодит ДНБ 2022 онд 2.5%, 2023 онд 4% байна. Өсөлт гол нь уул уурхайн секторын хувь нэмрээр хангагдана. - Дунд хугацаандаа өсөлтийн төлөв нь потенциал өсөлтөөс дээгүүр байна. - Махны үйлдвэрлэл нэмэгдэх, хүнс, эрчим хүчний үнэ глобал түвшинд буурч буй болон Оросын нефть бүтээгдэхүүний хөнгөлөлттэй үнэ зэрэг нь инфляцын болон гадаад дарамтыг хөнгөвчилнө.	нэгжүүдийн гадаад өр төлбөрийн менежментийн төлөвлөгөө, төсөөллүүдийн талаар бүрэн хэмжээний мэдээллээр хангагдсан байх ёстой - ТӨҮГ-дын ХО-ыг оролцуулаад төсвийн ХО-ыг эрс танаж, эрэмбэлэх шаардлагатай - ЗГ, Монголбанктай гадаад төлбөр тооцооны уялдаа холбоогоо сайжруулах - Импортын татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг зогсоох - Санхүүгийн нөхцөлүүд хатуурч буйтай холбогдон Монгол Улсын гаргасан бондын удирдлага, хөгжлийн банкны тэнцлийг сайжруулах - Инфляцыг бууруулахын тулд төсвийн шинжтэй үйл ажиллагааг 2023 онд зогсоох	алдагдуулж төсвийн шинжтэй санхүүжилт руу түлхсэн хэвээр байна. - Хэдий ийм төсвийн гүйцэтгэл төлөвлөснөөс сайжирч буй ч эрдсийн бус үндсэн тэнцэл ихээхэн алдагдалтай хэвээр, ХО-ын хойшлуулсан зардлууд импортыг нэмэгдүүлэх, ханш сулруулах, инфляц нэмэгдүүлэх үр дагавруудтай байна. - Дотоодын хувийн секторын сул идэвхжил өндөр инфляц, зээлийн нөхцөлүүд олдоц зэргээс болж нэмэгдэхгүй байна. - 2023 оны эцэс хүртэл инфляц өндөр түвшинд байж зорилтот түвшинд очихооргүй байна. - Урсгал дансны алдагдал сорилт байсан хэвээр, ГВУН хангалттай түвшинд хүрэхээргүй, 2023-2024 онд гадаад бондын төлбөр, гадаад өрийн дарамт том сорилт хэвээр байна.	нөөц нэмэгдүүлэх, ханшийн дарамтыг сулруулахад сөрөг нөлөөлж, импортыг нэмэгдүүлсэн. - Төсвийн алдагдал, тэлсэн бодлого, засгийн газрын гадаад өрийн удирдлага хоорондоо холбоогүй. - Төсвийн шинжтэй үйл ажиллагаа, сонгуулийн орчин дагасан, төсвийн тэлсэн бодлого хэрэгжүүлсэн. - Монголбанкийг үндсэн зорилтоос ил холдуулсан эрх зүйн болон бодлогын шахалт үүссэн нь инфляцын зорилтот түвшнээс давсан үнийн ерөнхий өсөлтийг бий болгож, эдийн засгийн дотоод тэнцвэрийг алдагдуулсан.	цикл сөрсөн” өсөлтийн хүртээмж, тогтвортой байдлыг хангах зорилттой байх, төсвийн тогтвортой байдалд хяналт тавих институцийг жинхэнэ бие даасан, хараат бус статустай болгох эрх зүйн өөрчлөлт хийх - 2022 оны ДНБ-ий өсөлт төсөөллөөс давж 4.8% болсон ч нийт нийлүүлэлтийн тал дээр өсөлт эмзэг хэвээр байна. Ихэнх секторын өсөлтөд оруулсан хувь нэмэр маш бага хэвээр, ХАА, бөөний ба жижиглэн худалдаа, БЦТ өсөлтийн гол хувь нэмрийг эцсийн хэрэглээ, МЭХҮЗӨ хангасан байна. Өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулалтын хувь нэмэр бараг байхгүй, бараа материал, бэлэн бүтээгдэхүүний л нөөц гол хувь нэмрийг оруулсан байна. Цэвэр экспорт -7.8% , МЭХҮЗӨ +3586.2 тэрбум төгрөг байна. - Гадаад худалдааны нэрлэсэн тэнцэл 3836.0 сая доллар болсон ч бодит тэнцэл нь 1571,5 сая доллар байна. Гадаад худалдааны нөхцөлийн индекс -28,2% болж муудсан, үүний дотор экспортын үнийн индекс -22.9%, эрдэс бүтээгдэхүүний экспортын үнэ -32.1% буурсан ба 2023 онд үргэлжлэхээр байна (ерөнхий хандлага). Импортын үнийн индекс өмнөх оноос эрс нэмэгдэж 107.6% болсон. - 2022 онд үйлдвэрлэгчийн үнийн индекс 20.3%, худалдааны салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс 26.8% нэмэгдсэн, хэрэглээний үнийн индекс 2 оронтой тоонд, ДНБ-ийн дефлятор 15.8%, ӨЭХЗ-ын дефлятор 9.7% байгаа нь 2023 онд
--	--	--	---	--

	- Банкны секторын гүйлгээний чадварыг дээшлүүлэх, Монголын банкинд хөрөнгийн их хэмжээний алдагдлаа багасгах, үйл ажиллагааны бие даасан байдлаа сайжруулах, мөнгөний бодлогын итгэлийн түвшинг нэмэгдүүлэх боломж олгох - Монголбанкны мөнгөний бодлогын талаар авсан арга хэмжээнүүд зүйтэй бөгөөд цаашдаа банкны секторын тогтвортой байдлыг хангах, төсвийн шинжтэй арга хэмжээнүүдэд үл оролцох, инфляцын хүлээлтийг аргамжих, инфляцын хүчин зүйлүүдэд болон мөнгөний бодлогын төлөвөө олон нийтэд тодорхой тайлбарлаж байх - ЗГ-ын зүгээс Монголбанкны инфляцыг	- Гадаад санхүүгийн нөхцөлүүд муудаж түүхий эдийн үнэ хэлбэлзэл ихтэй байна. - Монголын банкуудын корреспондент харилцааг US, UK хэдий хүчтэй дэмжиж буй ч Оросын эсрэг авч буй хориг арга хэмжээний үр дагавруудаас болж эрсдэлд орох боломжтой - 2024 оны сонгуулийн өмнөх төсвийн тэлсэн бодлого, санхүүгийн болон ТӨҮГ-дын алдагдал - Эдийн засгийн өсөлтийг хангах бодлого гол нь уул уурхайн эдийн засагт анхаарч, уул уурхайн бус эдийн засгийн өсөлтийг хангах бодлого төлөвлөж хэрэгжүүлээгүй. - ГВУН-ийг эзэмшиж удирдах, валютын ханшийн менежментийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүх төрлийн мэдээллийг бүрэн авах боломжийг	- Уул уурхайн бус төсвийн үндсэн алдагдлыг багасгах бодлого байхгүй. - Төсвийн тэлсэн бодлого баталж хэрэгжүүлэхдээ импорт эрс нэмэгдэх түлхэц болох цаашлаад валютын ханш, инфляцад дарамт үзүүлэх зэргийг тооцоогүй. - ГВУН-ийг эзэмшиж удирдахад шаардлагатай бүх төрлийн мэдээллийг бүрэн бөгөөд шуурхай авч байх боломжийг Монголбанкнд хуулиар болон де-факто олгоогүйн улмаас валютын нөөц бүрдүүлэгч гол ТӨҮГ-уудад валютын удирдлага ил тод бус, нууцын зэрэглэлд орж, тэдгээр нэгжийн	инфляцыг 1 оронтой тоонд хүргэх зорилт биелэгдэхгүйд хүргэхээр байна. ДНБ-ий төсөөлөл 5%-иас 7-8%, бүр 8-9% хүрч өсөх боломжтой. Энэ өсөлтөд нийт нийлүүлэлтийн талд уул уурхайн үйлдвэрлэлийн бодит тоо хэмжээний өсөлт, нийт эрэлтийн талд хөрөнгө оруулалтын идэвхжил нэмэгдэх нь гол хүчин зүйл болох төлөвтэй байна. - Ийм орчинд мөнгөний бодлогын төлөвийг цаашид хатууралгүйгээр тогтвортой хадгалах, эдийн засгийн тухайн үеийн байдлыг харгалзан багахан нэгжээр бууруулж эдийн засгийн идэвхжилийг хангах, мөнгөний нийлүүлэлтийг харьцангуй доогуур, жигд өсгөх бодлогыг хэрэгжүүлэх, энэхүү бодлогыг хэрэгжүүлэх төсвийн орчныг бүрдүүлэх нь чухал байх болно. - Уул уурхайн бус эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэх сэдэл дээр суурилсан бодлогыг тодорхойлж хэрэгжүүлэх нь ЗГ-ын дунд хугацааны тэргүүлчлэлийн бодлого байвал зохих бөгөөд Монголбанкны хувьд ийм бодлогод тохирсон мөнгө, санхүүгийн орчныг үүсгэх шаардлагатай. - Монголбанкийг үндсэн зорилтоос нь де-факто холдуулсан эрх зүйн болон бодлогын шахалтыг арилгаж, зорилтын түвшнээс давчихсан байгаа 2 оронтой инфляцыг 2023 онд зорилтот түвшнээс хэт хол биш түвшинд оруулах хүчин чармайлтыг ЗГ
--	--	---	---	--

	тогтворжуулах хүчин чармайлтыг а) нийлүүлэлтийн гацааг арилгах б) төсвийн чамбай байдлыг хангаж дотоод эрэлтийг багасгах с) төсвийн татаас болон нийгмийн эмзэг хэсэгт хандсан бодлогын дэмжлэгээ зорилтын шинж чанартай болгох гэх мэт замаар дэмжих	Монголбанкинд олгоогүйн улмаас ЭТТ, Эрдэнэт ГОК зэрэг валютын нөөц бүрдүүлэгч нэгжүүдийн экспортын гэрээнүүд, тэдгээрийн шуурхай анхдагч статистик мэдээлэл иж бүрэн биш, тодорхой зохицуулалтгүй хэвээр байна.	экспортын гэрээнүүд, тэдгээрийн гүйцэтгэл хяналтгүй явагдаж, оффтек бартерын гэрээнүүд байгуулсан валютын урсгал болон түүний бүртгэл, хяналтын тогтолцоо алдагдсан.	нийлүүлэлтийн гаралтай хүчин зүйлүүдийн саад бэрхшээлийг арилгах төдийгүй төсвийн болон өрийн тогтвортой байдлыг хангах, ГВУН-ийг нэмэгдүүлэх дунд хугацааны зорилтот хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжүүлэх, импортын эрэлтийг хөөрөгдөхгүй байх тоо хэмжээний болон үнийн өсөлтийг зохистой удирдах бодлого хэрэгжүүлэх замаар дэмжих шаардлагатай. - ГШХО-ыг дэмжих эрх зүйн болон институцийн орчныг сайжруулах чиглэлээр ОУСКорпорацаас гаргасан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх, бизнесийн орчлын реформыг тууштай үргэлжлүүлэн өрсөлдөх чадварыг түвшнийг дээшлүүлэх нь чухал.
--	--	--	---	---

Эх сурвалж: Зохиогчийн тооцоо

**II. “Хадны завсар хавчуулагдсан халиуны зулзага” буюу
“УИХ – Монголбанк - ОУВСан” хооронд үүссэн “Боломжгүйн
гурвалжингийн” тухай***

Үндэсний Аюулгүй байдлын хуралдаанаас гарсан зөвлөмж дээр суурилан УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо 2019 оны 4-р сарын 9-нд 04 дугаартай “Экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр Засгийн газар, Монголбанкинд чиглэл өгөх тухай” гэсэн гарчигтай тогтоол гаргаж үүний дагуу 2019 оны 6-р сарын 18-нд мөн хорооноос тогтоолын хэрэгжилтийн тайланг 2019 оны 7-р сарын 5-ны дотор ирүүлэхийг хүссэн албан тоотыг Монголбанкинд ирүүлжээ. Уг тогтоолд Монголбанкинд чиглэл болгосон заалтуудыг Хүснэгт 3-т үзүүлэв.

Мөн 2019 онд Олон улсын валютын сангийн төлөөлөгчид Монголд ирж ажилласан бөгөөд буцахдаа үлдээсэн дүгнэлт, зөвлөмжийн гол агуулга, үг өгүүлбэрийг SWOT хэлбэрт оруулан Хүснэгт 2-т үзүүлэв. УИХ-ын Байнгын хорооны тогтоолын заалтуудыг биелүүлэх, ОУВС-ийн дүгнэлт зөвлөмжүүдийг Монголбанк хэрэгжүүлэх учиртай. Гэхдээ энэ нь зөвхөн хуулинд заасан хүрээнд байх хэрэгтэй. Гэтэл дурдсан тогтоол, ОУВС-ийн дүгнэлт, зөвлөмжийн хооронд макро эдийн засгийн бодлогын агуулга, бодлогын хандлагын хувьд ихээхэн зөрүүтэй төдийгүй, ҮАБЗ-ийн зөвлөмж дээр суурилан гарсан тогтоолын үг үсэг, үзэл санаа нь УИХ өөрөө баталж өгсөн Монголбанкны тухай хуулийн үг үсэг, үзэл санаатай илт зөрчилдсөн байна.

Тиймээс зөвхөн энэ өгүүллийн зорилгоор бус Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн гол үзэл санаа, үг үсгийг бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчдад эдийн засаг, эрх зүйн талаас нь тайлбарлаж хуулийг үнэн зөв, гүнзгий ойлгоход тус дөхөм болох зорилгоор дэлгэрэнгүй тайлбар хийлээ. Эдгээр тайлбар болон Хүснэгт 2 болон Хүснэгт 3-т үзүүлсэн бодлогын харьцуулалтыг уншиж танилцсаны дараа энэхүү бүлгийн “задгай” гарчгийн учир ойлгогдоно.

Хүснэгт 2. ОУВСангийн үнэлгээ, дүгнэлтийг SWOT дүн шинжилгээний хэлбэрт оруулсан хүснэгт

Strength	Weakness	Opportunities	Threats
1. 2016 оноос эдийн засгийн өсөлт эрчимтэй сэргэж байна. - түүхий эдийн үнэ, экспортын эрэлт ↑ - ГШХО ↑ → ОТ - Дотоод эдийн засгийн орчин сайжирсан. 2. Төсвийн орлого ↑ ГВАН ↑ - 2019 оны 6 сарын байдлаар 3,6 тэрбум \$, 3. Өрхийн өр/орлогын харьцааны дээд хязгаар тогтоосон нь бодлогын оновчтой арга хэмжээ болов. 4. Төв банкны хуулийн нэмэлт өөрчлөлтүүд 5. Төсвийн шинжтэй хөтөлбөрүүдийг төв банк санхүүжүүлээгүй, үүнийг үргэлжлүүлэх нь ирээдүйд хямралд өртөх эрсдэлийг ихээхэн бууруулна.	1. Өрхийн өрийн дарамт нэмэгдэж, эдийн засгийн өсөлт хүртээмжгүй, ядуурал буураагүй, хэвээр байна. 2. Нийт экспортын 90% түүхий эд, түүний 90% зөвхөн нэг улс руу, ГШХО-ын 50% нь зөвхөн нэг төслөөс хамаарч байна. 3. Гадаад орчноос хамааралтай эмзэг байдал хэвээр, гэнэтийн цочролыг даван туулах нөөц боломж хомс 4. Инфляц 8% давсан, (үйлдвэрлэлийн зөрүү эерэг), төсвийн төлөв сул, Засгийн газрын өрийн дарамт их, ГВАН хангалтгүй. 5. Банкуудын активын чанар муу, өөрийн хөрөнгө хангалтгүй. 6. Өрхийн өр/орлогын харьцааны дээд хязгаарыг ББСБ гэх мэтэд мөрдүүлдэггүй. Санхүүгийн хэрэглэгчийн хамгаалалт сул.	1.* Оюу толгой амжилттай хэрэгжвэл ГХО-чдын итгэл ↑, төсвийн орлого, уул уурхайн ХО ↑2. Дэд бүтцийн томоохон төслүүдээ хэрэгжүүлбэл урт хугацаанд төлбөрийн тэнцэл, бүтээмжид эерэг нөлөөтэй. 3. Хөдөө аж ахуйн салбарын дэд бүтэц, стандарт, бэлчээр ашиглалтын зөв бодлого → ХАА бүтээгдэхүүний томоохон экспортлогч болох боломжийг ашиглах 4. Урсгал тэнцлийн алдагдлыг ДНБ-ий 2018 оны түвшингээс 4 нэгж % сайжруулах, төгрөгийн REER 9% сулруулах, макро эдийн засгийн бодлогыг чангаруулах 5. Бодлогын хүүг ↑ макро зохистой бодлого ↑, ханшийн уян хатан байдал → ГВАН ↑ орон зай үүсгэх 6. Инфляцыг 5-6% түвшинд барих зээлийн өсөлт <ДНБ өсөлт болгох, 7. Ипотекийг Засгийн газарт бүрэн шилжүүлж, банкны системийн талаарх арга хэмжээнүүдийг үргэлжлүүлэх	1. Эдийн засгийн төлөв муудах эрсдэл өндөр байна: - дэлхийн эдийн засгийн өсөлт ↓ - БНХАУ импортын нүүрсний орлуулалт хийвэл экспортын орлого огцом буурна; - Санхүүгийн тогтвортой байдал эрсдэлд орох (өөрийн хөрөнгийн дутагдалтай банкууд ба өрийн дарамттай өрхүүд); 2. БНХАУ-ын Ардын банкны своп хэлцэл, Засгийн газрын баталгаатай банкны бондын өрийг 2020 онд төлөх; 3. 2020 оны сонгуулийн өмнө болон дараах макро эдийн засгийн бодлогын тодорхой бус байдал; 4. Монгол Улсын гадаад өр, гадаад позиц сул байна: - сүүлийн 10 жил урсгал тэнцэл 20% (ДНБ) -аас илүү 5. ГВАН 50% ↓, өр/ДНБ 20% ↑ эрсдэл, 2016 оны хямралаас хүнд тусах төлөвтэй байгаа.

*Оюу Толгойн төслийн хэрэгжилт цаг хугацааны хувьд хойшлох нь Монголын эдийн засгийн тодорхой бус байдал, эрсдэл, өрийн дарамтыг нэмэгдүүлж 2019 оны төсөв, 2020-2022 оны макро орчны төсөөллийг өөрчилнө.

Хүснэгт 2-оос ОУВСангийн зөвлөмжид хэд хэдэн анхаарах зүйл байна. Үүнд:

1. Урсгал тэнцлийн алдагдал/ДНБ харьцааг 2018 оныхоос 4% сайжруулахын тулд төсвийн алдагдал/ДНБ-ий одоо байгаа болон 2020 онд төсөөлсөн харьцааг 1-2% хүртэл бууруулах нь минимум шаардлага юм. Үүнийг хийх улс төрийн орчин, цаг хугацаа, орон зай бий эсэхийг бодолцох. (Сонгуулийн өмнөх болон сонгуулийн жилийн төсөв.)
2. Төгрөгийн бодит ханшийг 9% сулруулах гэдэг зөвлөмж бол хэт хатуу бөгөөд нэрлэсэн дүнгээрээ 17% (инфляц 8% гэж үзвэл)-ийн шокийг монголын эдийн засаг дааж чадахгүй. Ханшийн иймэрхүү цар хэмжээний сөрөг үр дагавартай шок 2013 он, 2016 онд болж байсныг мартаж болохгүй.
3. Макро эдийн засгийн бодлогыг чангаруулах, бодлогын хүүг нэмэхийн хувьд бол төсвийн хэт тэлсэн бодлогыг үл тооцвол мөнгөний бодлогын төлөв хэт их сулраад байсан юм байхгүй бөгөөд accommodative буюу зохицсон төлөвт ихэвчлэн байж ирсэн, эдийн засгийн “халалт” гэсэн стандарт хэвшмэл ойлголт, түүнээс үүдсэн бодлогын алхам хийх бодит шаардлага үүсээгүй байна. “Тактикийн” үүднээс бодлогын хүүг 0,25 нэгж нэмж болох юм. Гэхдээ инфляцын хүлээлт 2019 оны II улирлын байдлаар харьцангуй тогтвортой, ханшийн хувьд ч мөн ижилдүү хандлагатай байгаа үед ийм алхам хийх нь ханш, инфляцыг өдөөх эрсдэлтэй юм.
4. ГВАН-ийг нэмэгдүүлэх 2 гол суваг нь экспорт ба ГШХО-ыг нэмэгдүүлэх бодлого бөгөөд эдгээрийг ОУВС мөн зөвлөмж болгосон. “Төсөв, мөнгөний бодлогыг чангаруулан, валютын ханшийн уян хатан байдлыг хадгалж, төгрөгийн бодит үйлчилж буй ханшийг сулруулах, гадаад хөрөнгө оруулалтын таатай нөхцөлүүдийг бүрдүүлж урт хугацаатай хөрөнгийн орох урсгалыг нэмэгдүүлэх замаар илүү тогтвортой гадаад валютын албан нөөцийг бүрдүүлэх боломжтой” гэж үзжээ. Энд дурдсан “гадаад хөрөнгө оруулалтын таатай нөхцөлүүдийг бүрдүүлэх” гэсэн асуудал бол Засгийн газрын хувьд онцгой анхаарвал зохих зүйл бөгөөд Олон улсын санхүүгийн корпорацаас “Монгол улсын хөрөнгө оруулалтын орчны шинэтгэлийн замын зураг” боловсруулж өгөөд бүтэн жил болж байхад түүнийг албажуулсан ямар нэг бодлогын шийдвэр Засгийн газраас өнөө хүртэл гараагүй л байна. Өрийн дарамт нэмэгдэх бодитой эрсдэл байгаа ойрын жилүүдэд ОУВС-ийн тооцооллоор Монгол улс ГВАН-өө 3-4 тэрбум доллароор нэмэгдүүлэх шаардлагатайг, үүнийгээ гадаад өр тавих замаар бус дотоодоосоо худалдан авах замаар бүрдүүлэх нь оновчтой гэж зөвлөсөн байна. Дотоодоосоо худалдан авахын тулд тэр нь бий болсон байх ёстой болохоор ГВАН-ийг хангалттай хэмжээнд бүрдүүлэх онцгой шаардлага үүсэж байна. Энэ нь дээр дурдсан ГШХО ба экспортыг нэмэгдүүлэх 2 гол суваг бөгөөд

гэхдээ энэ чиглэлээр тодорхой, үр дүнтэй бодлого боловсрогдоод хэрэгжтэл ихээхэн цаг хугацаа шаардагдах нь ойлгомжтой. УИХ-ын Эдийн засгийн байнгын хороон дээрх тогтоолд дурдсан 2 төмөр замын төслийн хөрөнгө оруулалт нь шийдэгдлээ гэхэд нэг нь 2019 онд, нөгөө нь 2020 онд ороод бодлогын зарлага биш валютын орлого оруулаад эхэлнэ гэдэг бол магадлал тун доогуур. Дээр нь зэс хайлуулах үйлдвэр гэсэн асуудал байна. Монгол Улс уул нь Эрдэнэтийн ГОК-оо түшиглээд одоо байгаа зэс боловсруулах 2 үйлдвэртэй хамтарсан зэсийн экспортын консорциум байгуулбал илүү бодитой болох юм. (Дотооддоо нефть боловсруулах үйлдвэр байгуулах төсөл “цагаан заан” болох, гадаад өрийн нэмэлт дарамт болох эрсдэлтэй байгаа үед) Ямар ч байсан 2019-2020 онд хэрэгжихгүй нь өндөр магадлалтай байгаа бөгөөд гэтэл 2020 оны эцсээс томоохон үнийн дүнтэй, өрийн өнөөгийн байдлыг улам муутгасан төлбөрүүд хийх шаардлагатай.

5. Ийм нөхцөлд Монгол Улсын хувьд өрийн удирдлагын 2016 оноос хэрэгжүүлж эхэлсэн бодлогыг үргэлжлүүлэхээс өөр сонголтгүй болно. Бодитойгоор үүсэх ийм эрсдэлүүдийг зөөлрүүлэх, хөнгөвчлөх, өнөөгийн нөхцөлд бодитой багасгаж болох “Б төлөвлөгөө” бол: а. *капиталын хэсэгчилсэн хяналтыг* улсын төсвийн орлого, экспорт, валютын нөөцийг голлон бүрдүүлэгч төрийн өмчит компаниудын хувьд хэрэгжүүлэх. б. гадаад худалдаа, ялангуяа экспортын “misinvoicing” буюу экспортын инвойс баримтыг буруу бүрдүүлэх явдлыг илрүүлэн нэмэлт орлого бүрдүүлэх гэсэн 2 арга зам байна. Эхний аргын хувьд дээр дурдсан *экспортын чиглэлтэй төрийн өмчит компаниуд, байгууллагын валютын орох, гарах урсгалд бүртгэлээр болон хяналтын бусад арга хэрэгслүүдээр дамжуулан хяналт тавьснаар экспортын орлого, төсвийн орлого төлөвлөлт, ГВАН-ийг нэмэгдүүлэх төсөөллийг илүү бодитой хийдэг болох юм. Өнөөгийн байдлаар Төр нь төрийн өмчит компаниудынхаа экспортын гэрээнүүдийг нууцын журмаар ч болов авч чаддаггүй, гэрээ контрактуудын үнийн болон бусад нөхцөлүүдийг тодорхой мэдэхгүйгээр нэгжсийн дундаж үнэ, олон жилийн дундаж, гадаад зах зээлийн баримжаа үнэ зэрэгт суурилан төсвийн орлогын төлөвлөлт, валютын нөөцийн төсөөллөө хийдэг ужигрсан практикаас салах хэрэгтэй. Үүнийг хэрэгжүүлэх хялбархан арга бол УИХ-аас баталдаг мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн талаарх төсөөлөлд дээрх заалтыг Засгийн газар, Монголбанкинд үүрэг болгох замаар шийдвэрлэх нэг гарц, ер нь бол цаашдаа төсвийн болон төсвийн тогтвортой байдлын тухай хууль, төрийн өмчийн тухай хуулиндаа тодорхой нэмэлт, өөрчлөлт оруулах нь зүйтэй. (Чили улсын Сангийн яам зэсийнхээ хамгийн том үйлдвэрлэгч Codelco компанийнхаа экспортын гэрээ контрактуудыг мэддэг, хянадаг, удирддаг шиг) 2010-2018 онд Монгол Улсын*

статистикийн мэдээллээр зэсийн баяжмалын экспорт 13,6 тэрбум доллар, төмрийн хүдэр, баяжмал, пирит 3,2 тэрбум доллар, нүүрс 13,6 тэрбум доллар, боловсруулаагүй нефть 3 тэрбум доллар нийт дүн нь 33,7 тэрбум доллар болсон ба мөн энэ хугацаанд ГВАН-ий жил бүрийн өсөн нэмэгдүүлсэн дүн 22 тэрбум, жил бүрийн цэвэр өсөлтийн нийлбэр нь 2,2 тэрбум доллар байгаа бөгөөд энэ 2 тоог эдгээр 4 бүтээгдэхүүний экспортын нийлбэр дүнд харьцуулбал 65,3% ба 6,5% байгаа нь ГВАН-ийг бүрдүүлэх энэ сувгийг сайтар ашиглах хэрэгтэйг харуулж байна. Хоёрдох арга зам буюу экспортын “misinvoicing” хувьд миний өмнө хийсэн судалгаагаар энэ үзэгдэл Монголд бас нэлээд хэмжээгээр prima facie түвшинд тогтоогдсон. Global Financial Integrity гэдэг мөнгө угаалт, санхүүгийн урсгал судалдаг think tank байгууллага Азийн улсуудын гадаад худалдааны “misinvoicing”-ийг судлаад Монголд мөн энэ үзэгдэл байгааг тодорхойлсон байсан. *Тиймээс энэ чиглэлээр Засгийн газар, Монголбанк ажлын хэсэг байгуулах, энэ чиглэлээр дээрх байгууллагаас эксперт урих гэх мэт тодорхой арга хэмжээ, үйл ажиллагаа хэрэгжүүлэх нь зүйтэй.*

6. *Бодлогын хүүг нэмэгдүүлээгүй, макро зохистой бодлогыг чангатгаагүй, ханишийн уян хатан байдлыг хангаагүйдээ ГВАН-ийг нэмэгдүүлэх орон зай үүсэхгүй байгаа бус харин өмнө дурдсан, Засгийн газраас шууд хамаарсан бодлогын алхмууд хийгдэхгүй байгаа учраас л ГВАН-ийг нэмэгдүүлэх орон зай үүсэхгүй байгаад асуудлын гол нь оршиж байна. Хэрэв эдгээр алхмыг хийхгүй бол ОУВС-ийн тооцоолсноор ГВАН 50% буурах, өр/ДНБ-ий харьцаа 20% нэмэгдэх бодит эрсдэл байгаа.*
7. “Инфляцыг 5-6% түвшинд барих, зээлийн өсөлтийг ДНБ-ийхээс бага болгох” гэсэн утгатай зөвлөмжийн хувьд авч үзвэл: а. инфляцын түүхэн мэдээлэл, түүний эрэлтийн болон нийлүүлэлтийн дүн шинжилгээ монголын нөхцөлд (зөвхөн монголынх бус хөгжиж буй улсуудын хувьд) инфляц нь мөнгөний цэвэр үзэгдэл гэхээсээ илүү нийлүүлэлтийн шалтгаан, хүчин зүйлүүдийн нөлөөлөл ихээхэн өндөртэй. б. инфляцын зорилтот түвшинг (5-6% гэх мэт) 8%-иас доогуур тогтоох нь (2020 оны мөнгөний бодлогын үндсэн чиглэлд орж магадгүй) төсвийн алдагдал, өрийн хуримтлалын зохистой түвшинг хэрхэн бодитой хангах, нийлүүлэлтийн гэнэтийн цочролыг хүлээн авах, зохицуулах засгийн газрын чадавх ямар байхтай шууд холбоотой тул үүнийг гол нь анхаарвал зохих юм. Олон жилийн турш инфляцыг 8%-ийн орчинд аргамжиж ирсэн инфляцын хүлээлтийн бодлогыг 5-6% руу оруулах нэг гол суваг нь инфляцын сагсанд 60% эзэлж буй импортын бараануудын нийлүүлэлтийн замын зургийг гаргаж импортод зориулж буй цаг хугацаа, зардал,

зайн дүн шинжилгээг хийсний үндсэн дээр барааны эргэлтийг хурдасгах нөөц боломжуудыг тодорхойлж хил, гааль, татварын үйл явцыг хялбаршуулах явдал юм.

8. ОУВСангийн зөвлөмж болон ОУВС-ийн суурин төлөөлөгчийн газраас зохион байгуулсан хуралд бараг анх удаа цаг уурын дулаарлын сэдвийг хөндөж Монгол Улсын хувьд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний томоохон экспортлогч болох боломжтойг дурдаж тус салбарын дэд бүтэц, стандарт, бэлчээр ашиглалтын зөв бодлого боловсруулах, түүний дотор малчдын татварын харилцаанд оруулах асуудлыг илтгэлдээ хөндсөн. Энэ бол Монгол Улсын хувьд чухал асуудал байсаар ирсэн бөгөөд эндээс малчдыг татварын харилцаанд оруулах асуудал нь энэ салбарын хөгжлийн зөв чиглэл гэдгийг Засгийн газар онцгой анхаарах нь чухал.

Хүснэгт 3. Экспортыг нэмэгдүүлэх талаар УИХ-ын ЭЗБХорооны 2019 оны 4 сарын 9-ний 04 тоот тогтоолоор Монголбанкинд чиглэл болгосон бодлогын арга хэмжээнүүд ба ОУВС-ийн зөвлөмжтэй харьцуулсан хүснэгт*

УИХ ЭЗБХ тогтоомж заалтууд (Монголбанкинд хамаарах хэсгүүд)	ОУВС-ийн бодлогын хандлага, ӨСХ-ийн заалт
2. Экспортын санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлэх; 2.1 ГВАН-ийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэрийн төслийн ТЭЗҮ-г эцэслэн боловсруулах, хөрөнгө оруулагч, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг Засгийн газартай хамтран хэрэгжүүлэх 2.2 “Таван толгой – Цагаан суварга – Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийг 2019 онд, Тавантолгой – Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг 2020 онд багтааж хэрэгжүүлж дуусгах” хөрөнгө оруулалт, эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийн эх үүсвэрийг Төв банкны тухай хуульд нийцүүлэн бүрдүүлэх боломжийг судалж танилцуулах; 2.3 Хөдөө аж ахуйн гаралтай экспортын бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээ, экспортын санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх бодлогын саналыг ХХААХҮЯ-тай хамтран боловсруулж шийдвэрийг төслийг танилцуулах. 2.4. Тогтоолын 1.7-д заасан эх үүсвэрийг (500 тэрбум төгрөгийн нэн хөнгөлөлттэй санхүүжилтийн эх үүсвэрийг 2019 оны II улиралд багтаан байршуулах) ХО-ын санд төвлөрүүлж уул уурхайн бус салбарын экспортыг дэмжих чиглэлээр хувьцааны болон зээлийн ХО-ыг хийх.	2. ОУВС зах зээлийн зарчимд суурилсан экспортын сэдэлжүүлэлтийг дэмждэг. 2.1. - Төсвийн шинжтэй хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхгүй байхыг онцгой анхааруулсан; - Оюу Толгой амжилттай хэрэгжүүлэх нь ГВАН-ийг нэмэгдүүлэх гол арга зам; - Урсгал тэнцлийн алдагдлыг 2018 оныхоос 4% (ДНБ %) сайжруулах; - Төгрөгийн бодит ханшийг 9% сулруулах ГВАН-ийг өсгөх орон зайг бодлогын хүүг нэмэх, ханшийн уян хатан байдлыг хангах замаар бий болгох; 2.2. - Төсвийн шинжтэй үйл ажиллагаа явуулж болохгүй; - Монголбанкны тухай хууль зөрчигдөнө. 2.3. Хөдөө аж ахуйн салбарын дэд бүтэц, стандарт, бэлчээр ашиглалтын зөв бодлого (Засгийн газрын чиг үүрэг, Монголбанкинд хамааралгүй. Бодлогын баримт бичигт Монголбанк санал өгч болно.) 2.4. Төв банкны тухай хуулиар хориотой. Зөвлөмж өгч болно.

Тайлбар:

* Хүснэгт 2 болон Төв банкны хуулийн тайлбарт илүү тодорхой тусгасан байгаа.

**III. Монголбанкны хуулинд буй эрх зүйн хязгаарлалтууд,
хуулийн эдийн засаг – эрх зүйн тайлбар**

1. 4-р зүйлийн 2. “Монголбанк өөрийн үндсэн зорилтын *хүрээнд* санхүүгийн зах зээл, банкны тогтолцооны *тогтвортой байдлыг хангах замаар* үндэсний эдийн засгийн тэнцвэртэй хөгжилд дэмжлэг үзүүлнэ”. Энэ заалт бол маш чухал суурь заалт бөгөөд эдийн засгийн хөгжлийн үйл явцад Монголбанк ямар байдлаар оролцож дэмжлэг үзүүлэхийг тодорхой заасан байна. Өөрөөр хэлбэл, төгрөгийн тогтвортой байдлыг хангах гэсэн үндсэн зорилтын хүрээнээсээ гарахгүй байх гэсэн хязгаарлалт, санхүүгийн зах зээл, банкуудын тогтолцооны тогтвортой байдлыг хангах замаар гэсэн дэмжлэг үзүүлэх арга замыг заасан хоёрдох хязгаарлалтыг хийж өгсөн байна. Энэ нь Монголбанкны үйл ажиллагааны чиглэлийг заасан 5 дугаар зүйлийн 8 дах заалт болох “макро зохистой бодлого хэрэгжүүлэх” гэсэн заалтаар хэрэгжинэ.
2. 11 дүгээр зүйл. Мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх арга хэрэгсэл гэсэн зүйлд 5 арга хэрэгслийг тодорхойлон заасан нь эдгээр арга хэрэгслээс өөр бусад арга хэрэгсэл ашиглаж болохгүйг хязгаарлаж өгсөн байна.
3. 12 дугаар зүйл. Банкны заавал байлгах нөөц.
12.2 Монголбанк банкны заавал байлгах нөөцийн хувь, хэмжээг 30%-иас дээшгүй байхаар тогтоох... гэсэн тоо хэмжээний хязгаарлалт хийж өгсөн нь мөнгөний захын үйл ажиллагаа зах зээлийн зарчимд суурилсан байх, мөнгөний бодлогын зах зээлийн арга хэрэгслүүдийг тэргүүнд тавьсан ач холбогдолтой юм.
4. 13 дугаар зүйл. Банкинд зээл олгох, санхүүгийн хэрэгсэл ашиглах.
13.1 Монголбанк мөнгөний зах дах мөнгөн хөрөнгийн нөөцийн илүүдэл, дутагдлыг зохицуулах зорилгоор банкинд зээл олгож, санхүүгийн хэрэгсэл ашиглаж болно. Энэхүү заалт нь мөн л маш тодорхой заалт бөгөөд Төв банк нь арилжааны банкинд мөнгөн хөрөнгөтэй холбоотойгоор мөнгөний зах зээл дээрх гүйлгэн чадварын (төлбөр түргэн гүйцэтгэх чадвар) илүүдэл, дутагдлыг зохицуулах зорилгоор л зээл олгох ба арилжааны банкны аливаа нэг төслийн санхүүжилттэй холбоотой үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй гэдгийг тодорхой зохицуулсан.
5. 15 дугаар зүйл. Нээлттэй захын үйл ажиллагаа явуулах.
15.1 Монголбанк мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхдээ үнэт цаас гаргах, түүнийг худалдан авах, худалдах, засгийн газрын үнэт цаас...-ыг мөнгөний зах дээр худалдах,

худалдан авах замаар нээлттэй зах зээлийн үйл ажиллагаа явуулах эрхтэй. Энэ зүйл нь 2 асуудлыг зохицуулж байна; төв банкны үнэт цаас гаргах, түүнийг худалдах, худалдан авах, Засгийн газрын үнэт цаасыг мөнгөний зах дээр худалдах, худалдан авах мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх хэрэгслийг зааж өгсөн нь Засгийн газрын төсвийн алдагдлыг санхүүжүүлэх, засгийн газрын аливаа нэг төслийг санхүүжүүлэх үйл явцад шууд болон шууд бусаар оролцохыг хязгаарлаж өгч буй хэрэг юм.

6. 16 дугаар зүйл. Банкнаас олгох зээлийн үлдэгдэлд хязгаарлалт хийх. “Монголбанк энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 1-ээс 4-т заасан мөнгөний бодлогын хэрэгслийг (1. банкны заавал байлгах нөөц, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох. 2. банкинд зээл олгох, санхүүгийн хэрэгсэл ашиглах. 3. хүүний нэгдсэн бодлого явуулах. 4. нээлттэй зах зээлийн үйл ажиллагаа явуулах) хангалтгүй гэж үзсэн тохиолдолд банкнаас иргэн, хуулийн этгээдэд олгох зээлийн үлдэгдэлд хязгаарлалт хийж болно.” Энэ заалт нь үйл ажиллагаа явуулж чадахгүй байгаа, 1-4-т заасан хэрэгслүүд хангалттай үр дүн өгөхгүй байгаа банкуудад хэрэгжүүлж болох чухал заалт юм. *Тухайлбал, харилцагчдад хамгийн өндөр хадгаламжийн хүү амлаж байгаа ч үйл ажиллагаа нь хуулийн дагуу бус, хэвийн бус явагдаж буй нь Монголбанкны хяналт шалгалтаар илэрсэн, 1-4-т заасан мөнгөний бодлогын хэрэгслүүдийг хэрэгжүүлсний үр дүн хангалттай бус байвал зээлийн үлдэгдэлд хязгаарлалт хийж болохоос гадна хадгаламжийн хүүд нь дээд хязгаар тогтоох эрх зүйн боломжтой гэсэн хэрэг юм.*
7. Засгийн газраас гаргасан үнэт цаасыг *Засгийн газрын хүсэлтээр* бусад этгээдэд зуучлан борлуулах ба төрийн мөнгөний бодлогын зорилт, зах зээлийн тухайн үеийн нөхцөл байдалд нийцэж байвал түүнийг худалдан авах, худалдах. Энэ заалт бол Засгийн газрын үнэт цаастай Монголбанк харьцахдаа баримтлах хязгаарлалт бөгөөд үүнийг бүр нарийвчлан тодорхойлсон заалт дараах хэсгүүдэд байгаа. Энэ заалтаар “мөнгөний бодлогын зорилт”-той нийцсэн байх, “зах зээлийн тухайн үеийн нөхцөлтэй” нийцтэй байх гэсэн 2 хязгаарлалтыг хийж өгснөөр мөнгөний бодлогын үйл ажиллагааны бие даасан, хараат бус байдлыг шууд бусаар (implicitly) зааж буй хэрэг юм.
8. 18 дугаар зүйл. Засгийн газарт зээл олгох.
 1. Монголбанк улсын төсвийн *улирлын чанартай* орлого, зарлагын зөрүүг нөхөхөд зориулж тухайн санхүүгийн жил дуусахаас өмнө төлөгдсөн байх нөхцөлтэйгөөр Засгийн

газарт зээл олгох буюу Засгийн газрын богино хугацаатай үнэт цаасыг худалдан авч болно.

2. Тухайн санхүүгийн жилийн түр хугацааны зээлийн үлдэгдлийн нийт хэмжээ нь дотоодоос төсөвт сүүлийн 3 жилд орсон орлогын дунджийн арван хувиас хэтрэхгүй байна. Дотоодоос төсөвт орох орлогод Засгийн газар өөрийн активыг зарж борлуулсаны орлого болон дотоодын зээллэг, үнэт цаас гаргаснаар өмнөх орлогыг хамааруулахгүй.

18.1 дүгээр заалтаар төсвийн орлого, зарлагын зөрүү нь улирлын шинж чанартай байх (уг зөрүү нь *засгийн газрын бодлогын үр дүнд* үүссэн бус байх, харин улирлын чанартайгаар орлогын хэмжээ зарлагаас бага байх), засгийн газарт олгох зээл нь тухайн санхүүгийн жил дуусахаас өмнө төлөгдсөн байх (11 сард зээл олголоо гэхэд 12 сарын 31 дуусахаас өмнө төлөгдсөн байх гэх мэт цаг хугацааны хязгаар), үнэт цаасны хугацаа нь богино байх гэсэн 2 хязгаарлалт тавьж байна. Өөрөөр хэлбэл, Төв банкны зүгээс Засгийн газрын төсвийн алдагдлыг санхүүжүүлэхэд (deficit financing) тодорхой хязгаар тавьж байна гэсэн үг. 18.2–оор зээлийн үлдэгдлийн хэмжээнд нь хязгаарлалт хийсэн нь а. орлогын эх үүсвэр нь дотоодынх байх (гадаад зээл, санхүүжилт биш гэсэн үг.) b. орлогын 3 жилийн дундаж гэдэг нь орлогын тогтвортой дунджийг тодорхойлж (өөрөөр хэлбэл, мөчлөгийн шинжтэй биш байх) түүний 10%-иас хэтрүүлэхгүй хэмжээнд байх тоо хэмжээний хязгаарлалт хийж өгснөөр төсвийн алдагдлын санхүүжүүлэлтэд хязгаарлалт хийж байгаа хэрэг юм.

9. 20¹ дүгээр зүйл. Банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжих зээл олгох. 1. Монголбанк *эцсийн зээлдүүлэгчийн хувьд* төлбөр түргэн гүйцэтгэх чадварт нь түр хугацааны хүндрэл үүссэн, өөрийн үйл ажиллагааны үр дүнд уг хүндрэл үүссэн, өөрийн үйл ажиллагааны үр дүнд уг хүндрэлээс гарч, зээлийг хугацаанд нь эргэн төлөх боломжтой, төлбөрийн чадвартай банкинд энэ зүйлийн 3 дах хэсэгт заасан Монголбанкны хүлээн зөвшөөрөх актив хөрөнгийн барьцаатай зээл олгож болно. Энэ зүйл бол дэлхийн улс орнуудын төв банкуудын хуулинд төв банкны чиг үүрэгт багтдаг “эцсийн зээлдүүлэгчийн үүрэг гүйцэтгэх” чиг үүргийг хэрэгжүүлж буй хэрэг бөгөөд харин манай энэ хуулинд чиг үүргүүд гэсэн тусгайлсан бүлэг байхгүй, үйл ажиллагаа гэсэн зүйлд ороогүй ч “эцсийн зээлдүүлэгч” гэсэн эрх зүйн нэр томъёолол энэ 20 дугаар зүйл дээр “гэнэт” гарч ирж байна. Ингэхдээ төлбөр түргэн гүйцэтгэх чадвар нь а. түр хугацааны хүндрэл үүссэн, энэ хүндрэлээс өөрийн үйл ажиллагааны үр дүнд гарах

чадвартай. б. зээлээ хугацаанд нь төлөх, төлбөрийн чадвар бүхий, шаардлага хангасан барьцаа хөрөнгөтэй байх гэсэн шалгуур хязгаарлалт хийж өгсөн нь энэ хуулийн 13.1-т заасан мөнгөн хөрөнгийн нөөцийн илүүдэл, дутагдлыг зохицуулах зорилгоор олгож буй зээлээс зарчмын хувьд ялгаатай юм.

10. 21 дүгээр зүйл. Гадаад валютын улсын нөөцийг эзэмших, удирдах

Энэ хуулийн 5 дугаар зүйл – Монголбанкны үйл ажиллагааны чиглэлийн 6-д заасан гадаад валютын улсын нөөцийг эзэмших, удирдах гэсэн заалтаас үүдэлтэйгээр:

21.1 Монголбанк эзэмшин, удирдаж байгаа гадаад валютын улсын нөөцийн гадаад төлбөрийг түргэн гүйцэтгэх чадвар, найдвартай байдлыг хангах үүрэгтэй гэсэн заалтын 2 гол үүрэг хязгаарлалт нь а. гадаад төлбөрийг түргэн гүйцэтгэх чадвар. б. найдвартай байдал юм. Энэ 2 үүрэг бүрэн биелсэн нөхцөлд л Монголбанк *санхүүгийн зах зээл дээр арилжаалагдах хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх замаар орлогыг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж болно* гэсэн заалт орсон байна. Энэ бол маш чухал заалт бөгөөд Монголбанк эзэмшиж, удирдаж буй валютын нөөцөө дээр дурдсан 2 үүрэг бүрэн биелсэн нөхцөлд санхүүгийн зах зээл дээр арилжаалагдах хөрөнгө оруулалт хийх буюу *шууд бус хөрөнгө оруулалт* (шууд хөрөнгө оруулалт хийж болохгүй гэсэн үг) хийх замаар *гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж болно* гэсэн үг юм. Энэ нь УИХ-ын ЭЗБХ-ны 2019 оны 4-р сарын 9-ний 04-р тогтоолын 2-ын 1-т заасан “гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд” гэж тодотгосон үйл ажиллагаанд оролцож болохгүй гэдгийг түүнчлэн 2.2-т заасан “төслийн бүтээн байгуулалт, эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийн эх үүсвэрийг Төв банкны тухай хуульд нийцүүлэн бүрдүүлэх боломжийг судалж, танилцуулах” гэсэн *заалтыг хэрэгжүүлэх эрх зүйн боломж байхгүй гэдгийг зааж буй хэрэг бөгөөд энэ зүйл төдийгүй өмнө авч үзсэн холбогдох зүйл, заалтуудыг зөрчинө гэсэн агуулгатай юм. Хуулийн үг үсэг, үзэл санаа үүнийг тодорхой илэрхийлж байгаа нь дээрх тогтоолын заалтууд Монголбанкийг өөрийн үйл ажиллагааны хуулиа ноцтой зөрчих эрсдэлд оруулж байгаа нь тодорхой байна. Монголбанкны эзэмшин (to own гэсэн үгээр бусад орны төв банкны хуулинд орсон байдаг) удирдаж буй ГВАН-ийг тэгвэл арвижуулах, нэмэгдүүлэх үүргийг, бодлогыг хэн хариуцах вэ гэсэн сонирхолтой эрх зүйн асуудал үүсэж байна. Энэ хуулиар орлого нэмэгдүүлэх арга замыг Монголбанкны хувьд заасан хязгаарлалт байгаа. Тэгвэл ГВАН-ийг нэмэгдүүлдэг хоёр гол суваг болох гадаадын шууд хөрөнгө*

оруулалт, экспортын орлогыг нэмэгдүүлэх асуудал нь Засгийн газрын асуудал бөгөөд эндээс ГВАН-ийг нэмэгдүүлэх чиглэлээр ҮАБЗ-ийн зөвлөмж ч УИХ-ын Байнгын хорооны тогтоол ч үндсэн субъект болох Засгийн газарт хандах ёстой бөгөөд Төв банкны хувьд энэ хуульд заасан Засгийн газартай харилцах гэсэн зүйлийн хүрээнд хамтран ажиллах, хамтын шийдвэр гаргах боломжтой юм. (тухайлбал, экспорт нэмэгдүүлэх, ГШХО-ын орчныг сайжруулах гэх мэт бодлогын хүрээнд)

11. 28 дугаар зүйл. Монголбанкны Ерөнхийлөгчийн *бүрэн эрх*, түүнийг хэрэгжүүлэх баталгаа.

Энд гол анхаарах зүйл бол “бүрэн эрх” гэсэн томъёолол бөгөөд энэ нь зөвхөн түүнд олгогдсон, бусад этгээдтэй хуваалцдаггүй, шилжүүлдэггүй, саадгүй хэрэгжүүлэхэд нь эрх зүйн баталгаа шаардагддаг эрхийн тухай юм.

28.1.3 УИХ-ын Байнгын хороо, Засгийн газар, холбогдох бусад байгууллагуудтай *шууд харилцаж* УИХ-ын чуулган, Байнгын хороо, Засгийн газрын хуралдаанд *өөрийн байр суурийг* илэрхийлэх;

28.1.8 төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай асуудлын талаар Засгийн газарт мэдээлэх, түүнтэй *хамтарсан шийдвэр гаргах*;

28.1.10 банкны шийдвэр банкны тухай хууль тогтоомж, *Монголбанкны шийдвэртэй* харшилж байвал түүнийг хүчингүй болгох;

Эдгээр заалтаас харахад УИХ, Засгийн газартай бие даасан, хараат бус институцийг толгойлж буй этгээдийн хувьд эдийн засаг, мөнгө, төсвийн гэх мэт өргөн хүрээтэй асуудлаар амаар болон бичгээр янз бүрийн хэлбэрээр шууд харилцах, өөрийн байр суурийг илэрхийлэх эрх зүйн de-jure боломжоор хангагдсан байна. Үүнийг бүтээлчээр de-facto ашиглах нь чухал юм. Гэхдээ 26 дугаар зүйлийн (Монголбанкны удирдлага) 6.4-т “үүрэгт ажлаа хангалтгүй биелүүлсэн” гэсэн дэлхийн улс орнуудын төв банкны тухай хуульд огт байдаггүй, хэт субъектив шинжтэй, яаж ч ашиглагдаж болох заалт оруулсан нь дээр дурдсан “бүрэн эрхүүдийг” “баллуурдсан” хэрэг юм.

12. 30-р зүйл. Монголбанк УИХ-тай харилцах .

30.1-30.3-т буй заалтууд нь “танилцуулна” гэсэн томъёололтой байгааг онцгой анхаарах хэрэгтэй. Олон нийтийн дунд болон УИХ-ын гишүүдийн дунд түгээмэл байдаг буруу ойлголт бол Монголбанк бол УИХ-ын харьяаллын байгууллага, тиймээс УИХ-д тайлагнах ёстой гэсэн ойлголт юм. Гэтэл “танилцуулах” “тайлагнах” гэсэн 2 томъёолол

нь эрх зүйн хувьд өөр өөр агуулгатай бөгөөд Монголбанк бол үндсэн зорилт болон үйл ажиллагааны хувьд бие даасан, Засгийн газраас хараат бус, төрийн мөнгөний бодлогыг боловсруулж хэрэгжүүлдэг, мөнгөний бодлогын хороо, хяналтын зөвлөл гэсэн хамтын шийдвэр гаргадаг бие даасан бүтэцтэй, Ерөнхийлөгчийн бүрэн эрх нь хуулиар баталгаажсан институцийн хувьд УИХ-д үйл ажиллагаагаа танилцуулах, засгийн газарт мэдээлэх л үүрэгтэй юм. Тиймээс “тайлан, тайлагнах” гэдэг томъёололыг Монголбанкнаас гаргаж буй аливаа баримт бичигт хэрэглэхгүй байх нь зүйтэй.

13. 31-р зүйл. Монголбанкнаас Засгийн газартай харилцах

31.2 Монголбанк Засгийн газраас хараат бус байна.

31.6 Засгийн газраас аливаа хэлбэрээр Монголбанкинд чиглэл өгөх, хуульд зааснаас бусад асуудлаар гэрээ, хэлцэл байгуулахыг хориглоно.

31.7 Монголбанк энэ хуулийн 15,18 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд Засгийн газарт шууд болон шууд бусаар зээл олгох, Засгийн газрын урт, богино хугацаатай үнэт цаасыг анхдагч, эсвэл хоёрдогч захаас болон шууд худалдан авахыг хориглоно.

Эдгээр заалт нь Монголбанкны засгийн газраас хараат бус байдлыг дэлгэрэнгүй тодорхойлж өгсөн бөгөөд тухайлбал 31.6-аар Засгийн газартай УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны тогтоолд заасан чиглэлүүдээр хамтарч ажиллах нь хориотой гэсэн үг бөгөөд түүнчлэн Засгийн газарт шууд болон шууд бус байдлаар зээл олгож болохгүй гэсэн нь мөн энэ тогтоолын үзэл санаа болох Засгийн газрын урт хугацаанд хэрэгжих дэд бүтэц, экспортын чиглэлтэй төслүүдийн санхүүжилтэд ямар нэг байдлаар оролцох нь шууд бус гэсэн томъёоллоор хориотой байна. 31.7 гэсэн заалтаар энэ нь бүр тодорхой илэрч байгаа бөгөөд түүнчлэн Засгийн газрын үнэт цаасыг хуульд зааснаас бусад тохиолдолд, анхдагч болон хоёрдогч зах зээлээс худалдан авах нь шууд бусаар санхүүжүүлж буй тул мөн хориотой байна.

31.¹ дүгээр зүйл. Монголбанкнаас Санхүүгийн зохицуулах хороотой харилцах.

1. Монголбанк нь Санхүүгийн зохицуулах хороо болон санхүүгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллах гурван талт харилцан ойлголцлын санамж бичиг үйлдэнэ.

Үндсэн зорилт болон үйл ажиллагааны хувьд бие даасан, Засгийн газраас хараат бус институцийн хувьд энэ non – binding утга агуулсан заалт маш чухал ач холбогдолтой бөгөөд энэхүү санамж бичгийг жил бүр байгуулах, түүний агуулга, зүйл заалт бүрээр

Монголбанк энэ хуулинд заасан үйл ажиллагааны чиглэлээр, төсвийн алдагдал, өрийн хуримтлал, ГВАН-ийн удирдлага, санхүүгийн тогтвортой байдал зэргийг багтаасан санамж бичгийн төсөл боловсруулж санаачилгыг өөртөө авах нь чухал ач холбогдолтой юм.

IV. Хавсралт

Хавсралт. Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийн төсөлд УИХ-аар хэлэлцэх явцад нэмэгдсэн заалтууд 2011-2023 он

2011	2.Зээлийн хүү бууруулах эдийн засгийн зохистой орчныг бүрдүүлэх хөтөлбөр боловсруулан хамтран хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /С.Батболд/, Монголбанк /Л.Пүрэвдорж/, Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/-нд даалгасугай.
	а/тухайн жилд улсад тушаах алтны хэмжээг батлагдсан нөөц, уулын ажлын төлөвлөгөө, олборлолтод үндэслэн тогтоож, биелэлтэд нь хяналт тавьж, хилийн хяналт, бүртгэлийг сайжруулж, татварыг бүрэн хураах ажлыг зохион байгуулах, дотоодод олборлосон алтыг худалдан авч мөнгөжүүлэх;
	б/дунд хугацаанд төгрөгийн гадаад валюттай харьцах ханш чангарснаар эдийн засгийн өрсөлдөх чадвар буурах үр дагаврыг зөөлрүүлэх зорилттой холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэн, үр дүнг танилцуулж ажиллах.
	а/хүнсний гол нэрийн барааны нийлүүлэлтийг тогтвортой байлгах нөхцөл бүрдүүлж, нийлүүлэлт доголдсоны улмаас үнийн хэлбэлзэл үүсэхээс сэргийлэх;
	б/үнэт цаасны болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зах зээлийг бодитойгоор хөгжүүлж, хөрөнгө оруулалтын сан бий болгох, Засгийн газрын үнэт цаасыг дотоодын зах зээлд гаргах, төсвийн алдагдлыг дотоодын эх үүсвэрээс санхүүжүүлэх;
	в/улсын экспорт, импортын түүхий эд, өргөн хэрэгцээний барааны дийлэнх нь дамжин өнгөрдөг хилийн боомт, төмөр зам, авто замын хүчин чадлыг нэмэгдүүлэн бодит эдийн засгийн өсөлтийг дэмжих;
	г/худалдаа зохицуулалт, түүхий эдийн биржийн тогтолцоог бүрдүүлэхтэй холбогдсон эрх зүйн актыг баталж мөрдүүлэх.
2012	Нэмэгдсэн заалт бхгүй
2013	Нэмэгдсэн заалт бхгүй
2014	1/Монгол Улсын зээлжих зэрэглэл, түүний өөрчлөлтөд нөлөөлсөн хүчин зүйлийн шинжилгээг тогтмол хийж, зээлжих зэрэглэлийг сайжруулах чиглэлээр зөвлөмж боловсруулан, Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо болон Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлд танилцуулж байх;
	2/Монголбанкны хараат бус байдлыг бэхжүүлэх, засаглалын бүтэц, зохион байгуулалтыг олон улсын жишигт нийцүүлэх зорилгоор хараат бус гишүүд бүхий мөнгөний бодлогын зөвлөлийг бий болгох чиглэлээр Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд холбогдох өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах;
	3/Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагааны үр дүн, шийдвэр гаргах механизм, хариуцлагын тогтолцоог сайжруулах, зөвлөлийн бүрэлдэхүүнийг өргөтгөх, санхүүгийн салбарт үүсэж болзошгүй эрсдэлийг үнэлэх, түүнээс хамгаалах бодлогын уялдааг

	хангах үр дүнтэй институци болгох чиглэлээр Төв банк /Монголбанк/-ны тухай хууль болон холбогдох бусад хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах.
2015	2/2015-2017 онд санхүүгийн салбарт зээлийн тасалдал үүсэх, системийн шинжтэй тогтворгүй байдал бий болохоос сэргийлэх зорилгоор "Эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Их Хурлын 2014 оны 34 дүгээр тогтоолд заасан арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх;
	3/Монголбанк, Засгийн газар хооронд макро эдийн засгийн нэгдсэн мэдээллийн тогтолцоог бий болгох, макро зохистой бодлого хэрэгжүүлэх хүрээнд төсөв, мөнгөний бодлогын уялдаа холбоог сайжруулах.
	4.Төгрөгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор макро эдийн засгийн гадаад тэнцвэрийг дэмжих, банкны салбарт эрсдэл хуримтлагдахаас сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээ авахыг Монголбанк /Н.Золжаргал/-нд даалгасугай.
	5.Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрийг зах зээлийн зарчимд шилжүүлэх замаар иргэдийн хэрэглээний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн тогтвортой тогтолцоог бий болгож, хөтөлбөрөөс үе шаттай гарах арга замыг сонгож хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар, Монголбанк /Н.Золжаргал/-нд тус тус даалгасугай.
2016	1/санхүүгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн салбарт эрсдэл хуримтлагдахаас сэргийлэх арга хэмжээний хүрээнд активын удирдлагын мэргэшсэн институцийг хөгжүүлж, эрх зүйн орчныг сайжруулах;
	2/улсын төсөв, санхүү, мөнгөний бодлогыг эдийн засгийн бодит секторыг дэмжих, хувийн хэвшлийн идэвхжилийг сайжруулахад чиглүүлэх;
	3/Монгол Улсын зээлжих зэрэглэл, эдийн засгийн орчныг сайжруулах чиглэлээр хамтран ажиллах;
	4/зээлийн эрсдэлийг бууруулж, санхүүгийн зуучлалын үр ашгийг нэмэгдүүлэх замаар зээлийн жилийн хүүг дунджаар 1-3 хувиар бууруулах бодлого боловсруулж, хэрэгжүүлэх.
2017	5/эдийн засгийн идэвхжилийг дэмжих, банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний өртгийг бууруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор дотоодын банкны тогтолцоог хамгаалах, гадаадын банк, түүний салбар нэгж болон бусад төрөлжсөн банкны үйлчилгээг нэвтрүүлэх боломжийг судалж, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;
	6/орон сууцны санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгон хөгжүүлэх, ипотекийн зээлийн хөтөлбөрийг макро эдийн засгийн төлөв байдалтай уялдуулан урт хугацаанд хэрэгжих боломжийг бүрдүүлэх.
2018	5/эдийн засгийн төлөв, санхүүгийн чадавхтай уялдсан урт хугацаанд тогтвортой хэрэгжих боломжтой орон сууцны ипотекийн тогтолцоог хөгжүүлэх;
	6/банкны салбар дахь чанаргүй зээлийг бууруулах, чанаргүй зээл үүсэхгүй байх орчинг бүрдүүлэх стратеги төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжүүлэх;
	7/Засгийн газрын дотоодын үнэт цаасыг бууруулах, арилжааны банкин дахь Засгийн газрын үнэт цаасыг мөнгөний бодлогын арга хэрэгсэл болгон ашиглаж эхлэх.
2019	7/Монгол Улсын гадаад валютын урсгалын мэдээлэлд дүн шинжилгээ хийж, улирал тутам тайлагнаж байх;
	8/ипотекийн зээлийг эдийн засгийн төлөв, санхүүгийн чадавхтай уялдуулж урт хугацаанд тогтвортой үргэлжлүүлэх;

	9/алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах асуудлыг судалж, шийдвэрлэх.
2020	6/"Зээлийн хүүг бууруулах стратеги"-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, зээлийн хүүг бууруулах хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох;
	7/ипотекийн зээлийн санхүүжилтийн эх үүсвэрийн тогтолцоог бий болгох үндэсний хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх;
	8/санхүүгийн зах зээлийн хөгжлийг дэмжих бодлого, зохицуулалт, хяналтын нэгдсэн тогтолцоо бий болгох хэрэгцээ, шаардлагыг судалж, олон улсын стандарт, зөвлөмжийн дагуу хууль, эрх зүйн орчны шинэтгэлийг хэрэгжүүлэх санал боловсруулж, Монгол Улсын Их Хуралд танилцуулах.
2021	8/цар тахлаас үүдсэн эдийн засгийн хүндрэлийн үед импортыг орлох, экспортыг төрөлжүүлэх, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэлтийг нэмэгдүүлэх, эдийн засгийг идэвхжүүлэхэд чиглэсэн мөнгө, санхүү, төсвийн бодлогыг хэрэгжүүлэх.
2022	4.Инфляцын зорилтыг хангах чиглэлээр Засгийн газраас хэрэгжүүлэх арга хэмжээг макро эдийн засгийн тогтвортой байдал, гадаад, дотоод тэнцвэрийг алдагдуулахгүйгээр дэмжин ажиллахыг Монголбанк /Б.Лхагвасүрэн/-д даалгасугай.
2023	9/Монгол Улсын Засгийн газраас дэвшүүлсэн "Халамжаас хөдөлмөрт" зорилтын хүрээнд ажлын байрыг хадгалах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, эрэлтэд нийцсэн ур чадвартай ажиллах хүчний нийлүүлэлтийг нэмэгдүүлж, мөнгөний болон төсвийн бодлогоор дэмжих;
	10/валютын захын үр ашиг, хүртээмжийг нэмэгдүүлэх, харилцагчдыг таньж мэдэх хууль, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, түүнчлэн үүсмэл санхүүгийн хэрэгслийн зах зээлийг хөгжүүлэх, хэрэглээг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авах;
	11/урт хугацааны тогтвортой санхүүжилтийн үйл ажиллагаа эрхлэх гадаадын хөрөнгө оруулалттай төрөлжсөн банкны эрх зүйн орчныг бүрдүүлэх.